



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм шинжлэх лабораторийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор 2023 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Уранзаяа	Дэд дарга
Гишүүд:	Д.Өлзийдулам	Эмийн чанар, аюулгүй байдлын тандалт судалгааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
	М.Жанчивням	Тооцооны нягтлан бодогч
	Б.Хувьтавилан	Лабораторын техникийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Ш.Энхзаяа	Эм шинжлэх лабораторын эрхлэгч

2.Хөрөнгө оруулалтын төсвийн төслийг цаг хугацаанд нь чанартай, шуурхай, үндэслэл бүхий боловсруулж, 2022 оны 06 дугаар сарын 27-ны дотор үр дүнг тайлагнахыг ажиллахыг Ажлын хэсэг (Д.Уранзаяа)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Батбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422 610136